

**“АРДЫН ДҮРСЛЭЛИЙН ХЭЛ-8” БУЮУ ТООНОЛЖИН ЗАМ  
(Өвөр монголчуудын аман билгийн жишээн дээр)**

Д.Батжаргал

**Түлхүүр үг:** Ардын аман билиг, ярианы найруулга, зүйрлэл, адилтгал, дүрслэх яриа, сэтгүүл зүйн хэл найруулгын онцлог, нийгмийн сүлжээ, үгийн алдаа

Бидний үндэс угсаа язгуур нэгтэй, үгийн урлаачид хайлан бичихдээ “халуун цусны тасархай, хатан ясны хэлтэрхий” хэмээн дуу алддаг өвөр монголчууд эх хэл аялгаа цэвэр байлгахын тулд ихэд хичээн хүүхэд залуусынхаа дунд “Дархан хэл” яруу найргийн уран уншлагын тэмцээнийг жил бүр явуулсаар хэвшил болжээ. Нэрнээс нь эхлэн бодсон ч монгол хэлийг эх орны хил шиг дархлан үзэж хүндэтгэхийн үүднээс ийнхүү эрхэмлэсэн нь лавтай. Үүнийг өгүүлэгч Өвөрмонголын их сургуулийн монгол судлалын салбарт багшлах далимдаа 2019 оны 14 дэх удаагийн наадмын шүүгчээр сууж цэцэрлэгийн багачуудаас өндөр дунд / манайхаар ахлах анги/-ын нийт 141 хүүхдийн монгол хэлний уран утга, эгшиглэнт айзам хэмнэлээр бүтсэн шүлэг яруу найргийг уянгалуулан уншихыг сонссон юм. Зарим сурагч монгол шүлгийг хятад аялгаар уншаад байхад учрыг асуухад хажууд суусан шүүгч маань “Ба багш аа, та ийм хүүхдийг аль болох өргөөрэй. Энэ чинь багаас нь хятад цэцэрлэгт явуулаад, сургуульд оронгуут бүх хичээлээ хятад хэл дээр үзээд монгол хэлгүй өссөн хүүхэд. Өөрөө дунд ангид оронгуут би монгол хүн юм байна. Та нар намайг яагаад монгол сургуульд оруулаагүй юм. Би бие дааж монгол хэл сурна хэмээн хичээл зүтгэлээрээ хэл үзэж шүлэг цээжлээд энэ тэмцээнд оролцож байгаа юм” гэж сануулсан нь тэднийг илүү их өрөвдөх сэтгэл төрүүлэв.

Дэлхийн даяаршлын эрин үед эх хэлээ авч үлдэхийн тулд харь хэлнээс зугтаалган өөриймшүүлэн нэрлэх талаар биднээс давуу зүйл ч харагдаж байв. Тухайлбал, бид дөрвөн замын уулзвараа “Баруун дөрвөн зам”, “Зүүн дөрвөн зам” хэмээн шууд нэрлэдэг бол тэд энэ огтлолцсон замыг “Тоонолжин зам” гэж тун аятайхан нэрлэнэ. Энэ тухай тэнхимдээ ярилцаж байхад “Ёстой зөв үг. Монголчууд довын толгой мөстөн тоонолжилж хагарна гэдэг шүү дээ” хэмээн Ардын багш, профессор С.Дулам нэгэнтээ өгүүлж билээ. Волейбол буюу гар бөмбөгийг “Алган бөмбөг”, микрофон гэдэг хэлэхэд төвөгтэй үгийг “дуун цацруулагч” онгоц гэдгийг “нисгэл” гэж нэрлэн заншжээ. Бидний үзэг, тосон бал, паркер гэх мэт олон янзаар нэрлэдэг зүйлсийг цөмийг нь “бийр” гэдэг сайхан үгээр хэлж байгаа нь монгол бичгийг бийрээр эрхэмсэг ганган татлан бичдэгтэй холбоотой биз.

Босоо монгол бичгээ хэвтээ үсгээр солилгүй босоо чигээр нь хэрэглэн хөгжүүлж яваа өвөр монголчуудаас ардын дүрслэлийн хэлний тансаг жишээ хайлаа. Өвөрмонголын их сургуулийн кирилл бичгийн нэгдүгээр ангийн оюутан Хэрлэн “Амандаа хийвэл хайлчихмаар, алган дээр тавибал бөмбөрчихмөөр өсгөсөн” гэж ээжийнхээ тухай зохион бичлэгтээ (ӨМИС хичээлийн төв асар 403 тоот) өгүүлсэн байв. Энэ үгийг дараа нь олон хүнээс сонслоо.

Өвөрмонголын их сургуулийн багш оюутнуудад “Ардын дүрслэлийн хэл” илтгэлээ тавьсны дараа ӨМИС-ийн сургалтын албаны дарга Болор “Манай Ордос Хянганаар нутагладаг

зон олон хавар болж мөс гэсэхээр “Хатан тайлж байна”, өвөл болж гол мөрөн хөлдөн газар дэлхий цас, мөс, цан хүүрэгт хучигдахаар “Хатан өмсөж байна” гэж хэлдэг гэлээ. Алшаа, Эзний голоор нутагтай Хөвүүдэй “Мөсөн дээр яваа илжиг шиг битгий тош тош дуугаргаад бай” гэж манай ээж хэлдэг гэсэн юм. Хөвүүдэй цэцэрлэгийн багш хүн юм.

Монголчуудын зочломтгой найрсаг занг дэлхийн улс үндэстэн нүүдэлчдийн соёл гарвалтай холбон тайлбарладаг. Данийн вант Аархусын сэтгүүл зүйн сургуулийн багш Мартин Бриум “Чөлөөт хэвлэл” төслийн хүрээнд монголын сэтгүүлчдэд хичээл заахаар ирэхдээ үнэхээр гайхаж байсан юм. Бид гайхашийг нь тайлахын тулд сургалтын дараа Тэрэлжийн чиглэлд явах замдаа “Та энэ хавиар нутаглаж байгаа дурын малчин айлыг заагаарай. Машин хүрч очих л газар бол бид таныг хүргээд өгнө” гэж хэллээ. Сэтгүүл зүйн багш хүнд өөрөөр нь сонгуулж байгаа нь урьдчилан ярьж тохирсон айлдаа очлоо гэсэн бяцхан хардалтаас зайлсхийсэн хэрэг. Хаврын цоохор цастай байхад замаас нэлээд зайдуу уулын энгэрт байгаа хот айлыг Мартин заав. Тэр зүг давхиад хүрвэл эзэгтэй гарч ирээд нохойгоо хорин биднийг найрсгаар урин гэртээ орууллаа. Зочноо танилцуулан хол ойрыг ярилцах зуур эзэгтэй шинэ цай чанаж өөрсдийн барьсан талхан дээрээ толгой шийрний царцаамаг зүсэж таваглан биднийг дайллаа. Данийн багш хоёр гурван зүсэм талх амтархан зооглоод “Мөнгө төлөх үү” гэж сэмхэн асуув. Бид толгой сэгсрэв. Завхан нутгийн гаралтай тэр айлд сайхан зочлуулаад гарсны дараа Мартин Бриум “Өмнө нь Монголд ирсэн Ларс Моллер, Флемминг Сейерсен нар танай хүмүүсийн зочломтгой зангийн талаар ярихаар яагаад ч үнэмшдэггүй байлаа. Өөрийн биеэр үзэж үнэмшлээ. Дани айлд урьдчилан ярьж тохиролгүй шууд яваад очвол урдаас буудна” гэж хэлээд инээлээ. Бид говь нутгийн эзэнгүй, цоожгүй айлын тухай ярихад тэрбээр бүүр их гайхаж толгойгоо бөнжигнүүлэн нүдээ дүрлийлгэсэн хэвээр байв. Ийм сайхан зочломтгой занг нүүдэлч малчдын аль ч нутаг уснаас олж болох ажээ.

Ордос, Хянган нутгийнхан “Онгойсон гэрт тонгойсон гийчин ирнэ” гэж хэлдэг нь үүний нэгэн жишээ. Монголчууд шиг ээрэм тал нутагт хаалга үүдээ цоожлолгүй орхидог улс үндэстэн даян дэлхийд хэр олон бол... Юм л бол хардаж сэрдэж хаалга үүдээ дангинатал түгжиж, нохой муураар мануулж, галуу тахиагаар сэрэмжлүүлж байдаг нь түгээмэл.

Хүүхэд залууст хандсан ажил үйл, ном эрдэмд сургахын чухлыг өгүүлсэн “ардын дүрслэлийн хэл”-ний жишээ өмнөх цувралуудад ч олон гарсан билээ. Хөлөнбуйр хотын Шинэ барга зүүн хошуугаар нутагтаа Уранмандах “Өндөсхийхийн нарнаар, өсөхийн цагаан хяруугаар, босохын сайхан нарнаар, бор цагаан хяруунаар” гэж хэлснийг оюутан Содон /кирилл бичгийн хоёрдугаар анги/ бичиж ирүүлсэн юм. Хүн мөнх залуу сайхнаараа байдаггүй, өтөлнө өвгөрнө гэдэг хорвоогийн жам хэн ч үүнээс тойрч, зайлах чадахгүй гэдгийг наран ургахтай зүйрлэн өгүүлжээ. Намрын өглөөний хяруу ч юутай үзэсгэлэнтэй хэдий ч юутай богинохон билээ. Мөн Уранмандах “Дархан хүний тэрэг няцархай, эмч хүний эхнэр эмгэгтэй” гэж хэлснийг бас ирүүлсэн байна.

Баруун үзэмчин хошууны малчин, 64 настай Долгор “Модтой ханилбал зогсож, морьтой ханилбал шогшино” гэж хэлснийг оюутан Ууганбаяр /кирилл бичгийн хоёрдугаар анги/ бичиж ирүүлжээ. Ерөөс монголчууд “зогсвол зоос алдана, хөдөлбөл хөлс авна”, “ажил хийвэл ам тосодно”, “залхуугийн гадаа түлээгүй, залгидгийн гэрт хоолгүй” гэж олонтоо хэлдэг билээ.

Бидний хэдэн зохиолчид хятадын Шанхай, Бээжин хотоор аялж явахад Бээжингийн их сургуулийн профессор Яо Кэчэн “Зоостой бол жороо Бээжин, зоосгүй хүнд зогсоо Бээжин” гэж хэлж байсан санаанд оров. Ер нь урлал, хийц, загвар, эртний дурсгал үзэж явах зуур Кэчэн багш байнга холбоо шүлэг хэлж байсныг дурдах хэрэгтэй. “Махнаас дүпү хурдан зардаг. Машинаас дугуй хурдан явдаг” хэмээн хориод жилийн өмнөх Бээжингийн амьдралаас гарсан шог үгийг дурсаж, түгжрэл түгжээн дунд дугуйн замтай бол юунд торох вэ? хэмээн биднийг бодогдуулсан юм. Тэр цагаас хойш 7-8 жил өнгөрч Улаанбаатар хот маань хагас хугас ч гэсэн дугуйн замтай болж байна.

МУИС-ийн профессор Л.Норовсүрэн хэдхэн жилийн өмнөх “Өвсний үнэртэй, найрын түрлэгтэй үзэмчин сөнөд нутаг” аян замын тэмдэглэлд “Нутгийн ардууд их ажил өрнөсөн намар цагийг “тоос хөдлөх цаг” гэдэг юм байна. Үнэхээр ч хадлан өвс, жимс ногоогоо хурааж, нүүрс түлээгээ базааж, өвлийн бэлтгэлээ хангах намрын цагаар тэр их бүтээн байгуулалтын бэлгэ тэмдэг болж хөх тэнгэрт цагаан тоос угалзарч харагддаг аж” гэж бичсэн байлаа. Яг үүнтэй төстэй үгийг оюутан Аруухан “Нохой хэлээ гаргах үед хийгээд бүтсэнгүй ажлыг тахиа хөлөө өргөх үед хийгээд юу бүтэх вэ?” гэдэг сонин үгээр илэрхийлж бичсэн байна. Нохой хэдийд хэлээ гаргах вэ?, мэдээж зуны халуунд. Тэгвэл тахиа хэдийд хөлөө өргөх вэ?, өвлийн хүйтэнд. Улирлын өнгө аясыг амьтан ахуйгаар төлөөлүүлэн хэлсэн нь ончтой юм. Юм бүхэн өөрийн гэсэн цаг хугацаатай. Хавар хийх ажлыг зун гээд хойшлуулж болохгүй, зун хийх ажлыг намар гээд үлдээж яавч таарахгүй. Тэрбээр бас “Зүү цуглавал зээтүү болно. Зүрх цуглавал бурхан болно”, “Санаа заяа хоёр нэг дор явахгүй, сахал хөмсөг хоёр нэг дор ургахгүй” гэдэг үгийг Зарууд нутгаасаа авчирсан юм. Монголчууд бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэж хэлдэгчлэн хэдий жижиг ч гэлээ зүү хэмээх оёдлын багажийг цуглуулвал газар ухдаг зээтүүний энд хүрэхийн дайтай дуслас далай дүүрдэг, дуулсныг хураавал эрдэм болдгийн үлгэр энэ буюу. Гэхдээ энд нэг сонин зүйл ажиглагдаж байна. Өвөр монголчууд маань газар тариалан эрхэлдэг ард түмний дунд байдаг болохоор ардын аман билигт энэ нөлөө тусжээ.

Мөн Зарууд нутгаас оюутан Шинжил /кирилл бичгийн хоёрдугаар анги/ “Нэг хүнд нэг буруутай, хоёр хүнд гурван буруутай. Буруугаа мэдэж танивал буруутай боловч айхгүй” гэдэг үгийг хичээл дээр танилцууллаа. Нэгнийхээ буруутай үйлдэл хийж байгааг мэдсээр байж хэлэхгүй нуун далдлах, хамтран хийвэл хэрэг улам хүндэрнэ гэдгийг дээрх үгээр залууст сануулан, буруугаа таньсан хүн бушуухан өөрийгөө татаж авбал гэмтэй хэдий ч санаа зовохгүй байж болох юм гэдэг санааг илэрхийлжээ.

Хулгайч, хумсалдаг хүнийг бид гар урттай, ховч нэгнийг хэл урттай “урт хэл хүзүү орооно” гэдэг бол өвөр монголчууд “Алтан хошуу өргөх”, “Алтан хумс хөдөлгөх”, хэн нэгнийг хуурмагаар магтан сайшаавал “цаасан малгай өмсгөх” гэдэг бол тэнд “Өндөр малгай зүүлгэх”, хэн нэгнийг дуугарахгүй болгох бол “амыг нь үдэх”, “хэлгүй болгох” гэдэг бол тэнд “Нохойн амьг өөх тосоор бөглөх” гэх зэргээр төстэй, тодотгол дүрслэлийн жаахан ялгаатай өгүүлж байна. Энд татсан жишээг оюутан Сацараа /кирилл бичгийн хоёр дугаар анги/ даалгаварт авчирсан юм.

Өнөөдөр Өвөр монголд эх бичиг, эх хэлнийхээ төлөө тэмцэж байна. Зарим нь уйлж, зарим нь жагсаж, хижиг, хил хоёроор зааглагдсан сэтгэл зүрх нэгтнүүд чөлөөт сонин хэвлэл, нийгмийн сүлжээгээр хэлэх үг, үзэл бодлоо илэрхийлж байна. Сэтгүүлч, яруу найрагч Д.Ган-Очир өөрийн эрхлэн гаргадаг “Монголчууд” сэтгүүлийнхээ шинэ дугаарт “Монгол бичгээ ерөөж бичсэн шүлэг”-тээ

...Цэцэн билигт цэцлэгдсэн

Оюун билигт ончирсон

Ур ухаанд уламжлагдсан

Утгын гүн-Монгол бичиг мину

Гол дагасан амин бичиг

Гоц содон дэлхийн бичиг

Эсгий туургатны эрдэнийн бичиг

Эцэг өвгөдийн сонгосон бичиг ээ... хэмээн дуу алдаж “үйсэн дээр ч, алтан дээр ч гялалздаг бичиг, хадан дээр ч, хана туурган дээр ч тодордог бичиг” гэж монгол үндэстний соёлын өв, эх хэлний дархлаа талаас нь гүнзгий гаргажээ. Энэ бол ганцхан жишээ. Ийм бахархал, бардамнал, хилэгнэл, харууслыг хэдэн арваар бичиж болох ч уншигч танд үлдээе.

Өвөр монголын “Одон” телевиз, “Өдрийн сонин”, “Солонго” сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл ядуухан, ардын сайхан хэлний жишээ баримт тэр бүрий тааралдахгүй, албаны мэдээ, ярилцлага зонхилсон шинжтэй байна. Энэ талаар сэтгүүлчид санаа тавьдаг эрэл хайлт хийдэг бол оюутан Содонгийн /кирилл бичгийн хоёрдугаар анги/ ирүүлсэн “Ёсгүй Ёндон ламын сударт үгүй”, оюутан Гэгээнзулын /мөн анги/ авчирсан “Юмны гуйранч хамаагүй, ухааны гуйранч хэцүү” гэдэг хоёрхон жишээн дээр олон янзын гаргалгаа гаргаж болно. Мэтгэлцээн, ярилцлага өрнүүлсэн ч болмоор. Японд “Мэдэхгүй зүйлээ асуух нь нэг удаагийн ичгэвтэр, мэдэхгүй чигээр үлдэх нь мянган удаагийн ичгэвтэр” гэсэн зүйр үг байдаг юм билээ.

Баруун үзэмчин хошууны Жирийн гол балгасын Баянгол гацааны 49 настай Сарнаагийн хэлсэн “Хожим ирж хоймор эзэллээ” /Мөн оюутан Гэгээнзул олж ирсэн/ гэдэг үг нь хойноос ирээд хот минийх, хотонд ороод хонь минийх гэсэн Монгол ардын аман зохиолын зүйр цэцэн үгийн нэгэн хувилбар юм. Сарнаа өөрөө “Олон хүргэнтэй айлын отгон охинтой гэрлэж хөрөнгө хогшилтой болсон хүргэнийг хэлж байгаа юм” гэж тайлбарласан байна. Манай 2017 онд хэвлүүлсэн тавдугаар цувралд, хоосон ирээд хөрөнгөжиж, бэлтэй болсон хүргэнээ “Ханын нүдээр ирээд хаалгаар багтахгүй болсон” хэмээн хэлсэн байдаг нь илүү уран нарийн дүрслэлтэй содон сонсогдож байна. Ард түмний энэ мэт цэцэн билиг яндашгүй. Ардын дүрслэлийн энэ мэт сайхан үгсийг хэрэглээнд оруулах талаар ХМХ-ээр нийгмийн зар сурталчилгаа байдлаар дэлгэрүүлэх ёстой.

Хэлний дархан байдал хууль гаргаснаар, захирамж шийдвэр олшруулснаар болохгүй. ШУА-ийн хэлний хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг “Эх хэл, бичиг” сэтгүүл нэгэн дугаартаа “Солонгос нүдний шил”, “Өнөөдөр орой аавын ууцыг чанана”, “Орос хүүхдийн дэлгүүр”, “Хөлдүү үхрийн мах”, “Эмэгтэй хүний нэг гараар унасан машин”, “Ээжийн гараар хийсэн хоол”, “Үхрийн гараар татсан мах”, “Чи зам дээр зогсож бай, би дайраад гаръя”, “Үхрийн өндөгтэй хуурга”, “Миний махыг хэн идчихэв ээ”, “Эмэгтэй автобусны жолооч” гэх мэт олон жишээ авчээ. Ингэж алдаатай бичиж, хэлгий зэлгий ярьдгаа хаацайлан “Бид буруу ярьж зөв ойлгодог” гэж цэцэрхдэг нь цэцэрхэл биш харин гутамшиг юм.

Ийм хазгай буруу, яриа, хөөрөөг сэтгүүлчид ХМХ-ийн булан хуудас, зай талбай, хөтөлбөр нэвтрүүлэг дундаа үргэлж ярьж анхааруулж баймаар юм. Тэгэхгүй болохоор нийгмийн сүлжээ дээр ойлгох, ойлгогдохын аргагүй зүйлсийг ярьж бичиж байна. Юм л бол “явжийн”, “хэвтжийн”, “болцон”, “ирцэн”, “гэхийн” гэх мэт буруу харилцах нь замаа алдаж байна.

Хэл бол хэн дуртай нь тоглодог тоглоом, хошин шогийн алиа салбадай нар марзганадаг марзганал биш. Монгол хүн бүхэн ээжийгээ хайрладагтай адил эх хэлээ хайрлан дархан байдлын төлөө санаа тавих хэрэгтэй. Телевизийн ёс заншил, соёлыг дээдэлсэн “Та таа, тунгаа”, “Агшин”, “Тунгаамал”, нэрт сэтгүүлч А.Авирмэд агсны хөтөлдөг байсан “Дөрвөн бэрх” зэрэг үзэгчдийн сэтгэлд хүрч байсан нэвтрүүлгүүдийг өнөө цагийн аяст тохируулан дэлгэрүүлмээр. Бидний өвөг дээдэс яагаад “Хэл доголохоор хөл догол” гэдэг юм. Бас яагаад “Турвалжин нөхөөс зөв тавьж чадахгүй, гурван үг тэгш хэлж чадахгүй” гэж хэлдэг юм. Үүнд ганцхан хариулт бий. **“ЭХ ХЭЛНИЙХЭЭ ТӨЛӨӨ ИРГЭН БҮР САНАА ТАВЬЖ, ЭЭЖИЙНХЭЭ НЭР ШИГ, ЭХ ОРНЫ ХИЛ ШИГ ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДААСАЙ”** гэсэн санаа.

**Номзүй**

**Батжаргал Д.** “Ардын дүрслэлийн хэл-5” буюу “ПО” багийн үгийн эрчим”. Пүрэв-Очир-70  
эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. МУБИС.

**Батжаргал Д.** 2012. *Хил хязгааргүй уран зохиол*. Цог сэтгүүл № 04

“Монголчууд” сэтгүүл 2020 №03 /39/

“Нээлттэй хаалга” /Open door/ сонин 2017 № 38 /168/

“Эх хэл, бичиг” 2014 № 04/08/

**Abstract**

In this paper, I wrote more examples which was choose examples from the Inner Mongolian people's oral tradition. Students sent me interesting idioms which are said in different local area. The most of examples were not published and introduced to the masses, so I have chosen some of them and explained comparing with words of modern Mongolian. Also I made criticism in the words which are used wrong among the mass and social media. Therefore, I would like to say some warning to the journalists who do not pay special attention for their own language clear and are not innovative to combat for our Mongolian language safety.